



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн
тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2025/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2054 он

Дарга, Тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 185

танай _____ ны № _____ т

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.МӨНХТУЛГА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 09 өдрийн А/280 дугаар захирамжаар 973.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах шийдвэр гаргасан боловч бараа үйлчилгээний зардлаас, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/283 дугаар тушаалаар Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэр гаргасан ч 125.0 мянган төгрөгийг нэг удаагийн шагнал урамшууллагаас хяналтгүйгээр гаргасан, Бүрэгхангай сумын сургуулийн дотуур байрны их засвараас үүссэн 8,000.0 мянган төгрөгийн өглөг үүссэнийг 2023 оны санхүүгийн тайланд тусгаагүй, сумын 100 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд спорт наадмын цогцолбор барихад цемент дутагдаж 1200 шуудай буюу 60 тн цемент Булган сумын иргэнээс авч 1 шуудай цемент тухай үеийн ханш 23.0 мянган төгрөг, 1200 ширхэг нь 27,600.0 мянган төгрөгийн өглөг үүссэнийг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр 20,000.0 мянган төгрөгийг тухайн иргэн рүү шилжүүлж 7,600.0 мянган төгрөгийг тайлант онд өглөгөөр тусгаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1,

632502316

20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4 дахь заалт, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй ба бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 42 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	49,025,944.00	109,378,802.40
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,006,399,817.00	5,761,961,984.55
Нийт хөрөнгийн дүн	5,055,425,761.00	5,871,340,786.95
Нийт өр төлбөрийн дүн	1,591,812.20	11,754,365.14
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,053,833,948.80	5,859,586,421.81
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,055,425,761.00	5,871,340,786.95
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,880,418,949.00	2,172,140,660.72
Үйл ажиллагааны зардлын дүн	1,087,125,893.94	1,328,162,843.71
Үйл ажиллагааны үр дүн	793,293,055.06	843,977,817.01
Үйл ажиллагааны бус үр дүн	(770,000.00)	(38,225,344.00)
Үйл ажиллагааны нийт үр дүн	792,523,055.06	805,752,473.01
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	721,053,754.60	5,053,833,948.80
Тайлант оны үр дүн		805,752,473.01
Эцсийн үлдэгдэл		5,859,586,421.81
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	799,082,938.00	1,193,710,989.00
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	750,159,203.00	1,184,738,989.00
Үйл ажиллагааны ЦМГ	48,923,735.00	8,972,000.00
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(48,923,735.00)	(8,972,000.00)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		998703676.14
Урсгал зардал		989176776.14
Хөрөнгийн зардал		9,526,900.00
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,030,120,000.00
Улсын төсвөөс санхүүжих		1,030,120,000.00
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Гурав.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 51.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 7.6 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Сумын 100 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд спорт наадмын цогцолбор барихад дутагдсан цементийн үлдэгдэл төлбөрийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгууллаа.
-

5.1 Төлбөрийн акт

2 Албан шаардлага

1. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2024 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн А/33 тушаалаар мөрийн хөтөлбөрийн сэтгүүл хэвлүүлсэн, Засаг даргын нөөц хөрөнгөөс мөрийн хөтөлбөрийн видео бичлэг хийлгэсэн, бараа үйлчилгээний бусад зардлаас 2,000.0 мянган төгрөгийн мөрийн хөтөлбөрийн сэтгүүлийн эх бэлтгэхэд зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

2. Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 09 өдрийн А/280 дугаар захирамжаар 973.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах шийдвэр гаргасан боловч бараа үйлчилгээний зардлаас, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/283 дугаар тушаалаар Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэр гаргасан ч 125.0 мянган төгрөгийг нэг удаагийн шагнал урамшууллаас хяналтгүйгээр гаргасан байна. Бүрэгхангай сумын сургуулийн дотуур байрны их засвараас үүссэн 8,000.0 мянган төгрөгийн өглөг үүссэнд 2023 оны санхүүгийн тайланд тусгаагүй нуун дарагдуулсан, сумын 100 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд спорт наадмын цогцолбор барихад цемент дутагдаж 1200 шуудай буюу 60 тн цемент Булган сумын иргэн Н.Дэмчигсүрэнгээс ачуулан хүргүүлсэн, төлбөр мөнгийг 100 жилээс өмнө шилжүүлэх байсан 1 шуудай цемент тухай үеийн ханш 23,000.0 төгрөг, 1,200 ширхэг нь 27,600,000 төгрөгийн өглөг үүссэнийг өглөгөөр тусгаагүй 2024 оны 12 дугаар сарын 27-нд 20.0 сая төгрөгийг тухайн хүн рүү шилжүүлж 7.6 сая төгрөгийн өглөг үүссэн.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Нийгмийн даатгал 2948.4, гэрэл цахилгаан 894.3, байгууллагад төлөх 311.6 мянган төгрөгийн өглөгтэй.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

2. Байгууллагаас авах буюу бусад зардлын тооцооны 18,037.0 мянган төгрөгийн авлагатай.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

3. Шилэн дансны 171 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээлл ийг тусгахгүй орхигдуу лсан		Буруу тусган илэрхийлс эн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа гүй			
	Тоо	Дүн	То о	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын 100 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд спорт	1	7,600.0					1	7,600.0				

наадмын цогцолбор барихад дутагдсан цементийн үлдэгдэл төлбөрийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгах.												
Дүн	1	7,600.					1	7,600.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 09 өдрийн А/280 дугаар захирамжаар 973.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах шийдвэр гаргасан боловч бараа үйлчилгээний зардлаас, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/283 дугаар тушаалаар Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэр гаргасан ч 125.0 мянган төгрөгийг нэг удаагийн шагнал урамшууллаас хяналтгүйгээр гаргасан байна. Бүрэгхангай сумын сургуулийн дотуур байрны их засвараас үүссэн 8,000.0 мянган төгрөгийн өглөг үүссэнг 2023 оны санхүүгийн тайланд тусгаагүй нуун дарагдуулсан, сумын 100 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд спорт наадмын цогцолбор барихад цемент дутагдаж 1200 шуудай буюу 60 тн	1	16,698.0							1	16,698.0		

цемент Булган сумын иргэн Н.Дэмчигсүрэнгээс ачуулан хүргүүлсэн, төлбөр мөнгийг 100 жилээс өмнө шилжүүлэх байсан 1 шуудай цемент тухай үеийн ханш 23,000.0 төгрөг, 1200 ширхэг нь 27,600,000 төгрөгийн өглөг үүссэнийг өглөгөөр тусгаагүй 2024 оны 12 дугаар сарын 27-нд 20.0 сая төгрөгийг тухайн хүнрүү шилжүүлж 7.6 сая төгрөгийн өглөг үүссэн.											
Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2024 оны 11 дүгээр сарын 11-ний А/33 тушаалаар мөрийн хөтөлбөрийн сэтгүүл хэвлүүлсэн, Засаг даргын нөөц хөрөнгөөс мөрийн хөтөлбөрийн видео бичлэг хийлгэсэн, бараа үйлчилгээний бусад зардлаас 2,000.0 мянган төгрөгийн мөрийн хөтөлбөрийн сэтгүүлийн эх бэлтгэхэд зарцуулсан.	1	5,300.0			1	5,300.0					
Нийгмийн даатгал 2948.4, гэрэл цахилгаан 894.3, байгууллагад төлөх 311.6 мянган төгрөгийн өглөгтэй.	1	4,154.3					1	4,154.3			
Байгууллагаас авах буюу бусад зардлын тооцооны 18,037.0 мянган төгрөгийн авлагатай.	1	18,037.0					1	18,037.0			
Шилэн дансны 171 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1	0					1	0			
Дүн	6	51,789			1	5,300.0	3	22,191	1	16,698.0	